Маягт-1

# НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2023.06.02

| Дугаар | ХБТББ-т тусгагдсан зорилт, үйл ажиллагаа | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/ | Суурь түвшин | Зорилтод хүрэх түвшин, үр дүн (Хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) | | | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Түвшин | Төсвийн гүйцэтгэл | | |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| 3.1. Мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглан хотын цогц үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, нээлттэй, чирэгдэлгүй хүргэдэг ухаалаг хотыг бий болгоно. | | | | | | | | | | | | |
| 2.1.21 | НХТЖҮЧ 4.1.3 НЗДҮАХ-3.1.4 | Нийслэлийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийг улсын нэгдсэн мэдээллийн системтэй уялдуулан нэвтрүүлнэ. | 2023 | НЗДТГ-ын ХБТХ<br><br>НЦХМТГ | Нийслэлийн төсөв | 300.0 | - | 100 | - | - | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 15 дугаар хуралдааны тэмдэглэлээр Төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем /PIMIS/ системтэй ижил төрлийн цахим систем үүсгэхгүй байхыг үүрэг болгосны дагуу тус ажил хийгдэх боломжгүй болсон болно. | 30% |
| 3.1.2 | НХТЖҮЧ 5.3.3 НЗДҮАХ 4.1.1 | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, Төрийн үйлчилгээний операторын болон нэгдсэн портал www.e-mongolia.mnсистемд холбоно. | 2023 | НЦХМТГ НЗДТГ-ТЗУХ, НҮНТ | Нийслэлийн төсөв | - | ХУР системээр дамжуулан 29 байгууллагын 256 нэр төрлийн үйлчилгээг үзүүлж байна. | ХУР системээр дамжуулан 35 байгууллагын 320 нэр төрлийн үйлчилгээ болгон нэмэгдүүлсэн байна | - | - | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад үзүүлдэг Төрийн үйлчилгээний операторын болон нэгдсэн портал www.e-mongolia.mn системийн дэд систем болох Бизнесийн орчин дахь төрийн үйлчилгээг цахимжуулах "E-Business" платформд Нийслэлийн "Онлайн бизнес төв"-өөр үзүүлж буй бизнес эрхлэгчдэд зориулсан 10 байгууллагын 134 үйлчилгээг холбосон. Тус системийг ашиглан 2023 оны хагас жиллийн байдлаар **447,438** иргэн | 50% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | аж ахуй нэгж байгууллага хандаж **12,635** хүсэлтийг ирүүлснээс зөвшөөрсөн **8,405** хүсэлтийг батлуулахаар шилжүүлсэн болон шийдвэрлэсэн төлөвтэй үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө аваад байна. | |
| 3.1.10 | НХТЖҮЧ 5.2.3 НЗДҮАХ 4.1.3 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын "UB ERP" системийг шинэчилж, шинэ хувилбарыг хэрэглээнд нэвтрүүлнэ. | 2023 | НЦХМТГ | Нийслэлийн төсөв | 300.0 | 50% | 90% | - | | Нийслэлийн төрийн байгууллагуудын уламжлалт цаасан суурьт үйл ажиллагаанд шинэчлэлт хийх замаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлэн, байгууллага нэгжүүдийн уялдаа холбоо, мэдээллийн урсгалыг сайжруулах нийслэлийн дотоод удирдлагын UBERP системийг нэвтрүүлж, энэхүү системийг нийслэлийн 1200 орчим байгууллага 30,000 гаруй албан хаагч ашиглаж өдөр тутмын үйл ажиллагаагаа 100% цахимаар гүйцэтгэж байна.<br>"UB ERP" системийн гар утасны аппликейшны хөгжүүлэлтийн техникийн даалгавруудыг боловсруулж бэлэн болгосон бөгөөд суурь системүүдийн бэлэн байдал хангагдаагүй улмаас төслийн ажил удааширч хөрөнгө оруулалтын эрх шилжүүлэх захирамжийн санал авах явц хүлээгдсэн болно. | 50% |
| 3.1.11 | НХТЖҮЧ 5.3.3 НЗДҮАХ 4.1.3 | "Call center" дуудлагын төвийг өргөжүүлнэ. | 2023 | НЦХМТГ | Нийслэлийн төсөв | 220.0 | 50% | 70% | - | | Нийслэлийн лавлагаа мэдээллийн төв буюу Call center дуудлагын төв 1800 1200 тусгай дугаарт Улаанбаатар хотын шуурхай удирдлага, зохицуулалтын төв, | 50% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | нийслэлийн Тээврийн үйлчилгээний газар, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Ус сувгийн удирдах газар, ОСНААУГ ОНӨААТҮГ-уудын тусгай дугааруудыг холбон 7/24 цагийн горимоор ажилладаг. “Call center” дуудлагын төвийг өргөжүүлэх тус төсөл, арга хэмжээний техникийн даалгаврыг боловсруулан Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж худалдан авах ажиллагааг зарласан боловч Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн дагуу нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зогсоосонтой холбоотой хэрэгжүүлэх боломжгүй болсон. | |
| 3.1.12 | НХТЖҮЧ 5.3.3 НЗДҮАХ 4.1.3 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хэмжээнд ашиглагдаж буй цахим технологи, програм хангамжийн бүртгэл, эрх, аюулгүй ажиллагааны журам боловсруулж, батлуулна. | 2023 | НЗДТГ-ын ТЗУХ<br><br>НЦХМТГ | - | - | 1 | | | | Нийслэлийн нутгийн захиргааны 11 байгууллага дотооддоо Мэдээллийн аюулгүй байдлын журам боловсруулан мөрдөн ажиллаж байна. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд болон албан хаагчдын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, албан хэрэглээний компьютер болон дагалдах тоног төхөөрөмжүүдийг гадна дотны халдлагаас хамгаалах, нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хангах зорилгоор нийслэлийн нутгийн | 50% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | захиргааны 47 байгууллагын сүлжээ, дата төвийн 50 физик сервер, виртуал 93 сервер, хадгалах төхөөрөмж, 130 системийн аюулгүй байдал, хэвийн ажиллагааг хангаж, 1257 хэрэглэгчийг нэгдсэн домэйнд холбон хэвийн ажиллагааг хангаж ажилласан. | |
| 6.1 Авто замын хөдөлгөөний төлөвлөлтийг оновчтой түвшинд төлөвлөж, авто замын хөдөлгөөний ачааллыг бууруулна. | | | | | | | | | | | | |
| 6.1.15 | НХТЖҮЧ 9.20.2 НЗДҮАХ 6.3.11 | Замын хөдөлгөөний удирдлага зохион байгуулалтын ухаалаг систем нэвтрүүлнэ. | 2023 | НЦХМТГ | Нийслэлийн төсөв | 7,435.0 | - | 100% | - | | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/207 дугаар захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2023 онд “Зам, тээврийн нэгдсэн систем”-ийн ажлын хүрээнд хэрэгжүүлэх Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ /RFID tag/-г суурилуулах ажлын тендерийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, шалгарсан компанитай гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн нийслэлийн хэмжээнд 100 цэгээр дамжуулан 442477 ширхэг цахим гэрчилгээг тээврийн хэрэгсэлд 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн суурилуулахаар төлөвлөж байна. | 70% |
| **ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ:** | | | | | | | | | | | | **50%** |
| Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан 2 зорилтын 6 арга хэмжээнээс 50 хувьтай хэрэгжсэн **5** арга хэмжээ байна. **Хэрэгжилтийн дундаж 50%-тай байна.** | | | | | | | | | | | | |

ХЯНАСАН:
НЦХМТГ-ЫН ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ,
САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Д.САЙНХҮҮ

НЦХМТГ-ЫН ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ,
САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН — Г.ЭНХЗУЛ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
НЦХМТГ-ЫН ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ,
САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН — Т.ОТГОНЖАРГАЛ